Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг дарга нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-д “Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах, түүнчлэн тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн төлөөлөгч мөн” гэж заасан ба мөн хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д “Сумын Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 59.1.1-59.1.23-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлдэг байна.

Мөн Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-д “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 14.2.1-14.2.12-т заасан бүрэн эрхийг, мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-д “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасан бүрэн эрхийг тус тус хэрэгжүүлэн, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаа аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчид нэгтгэн тайлагнадаг байна.

ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар тэжээлийн цех байгуулах ажлыг 99,100.0 мянган төгрөгөөр, сүү хөргөлтийн барилгын ажлыг 21,900.0 мянган төгрөгөөр, соёлын төвийн засварын ажлыг 308,000.0 мянган төгрөгөөр тус тус хийж гүйцэтгэсэн байна. Мөн эрэн хайх аврах бүлгийн барилгын ажил, хашаажуулах ажил, цэцэрлэгийн биеийн тамирын талбайн тохижилтын ажил, бага сургуулийн заалны засвар зэрэг томоохон ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

Нийгмийн хариуцлагын гэрээний хүрээнд Өвөржанчивлан суурин, нэгдүгээр багийн хогийн цэгийг булж дарсан байна.

Төв аймгийн Засаг даргын 2023 оны А/45 дугаар захирамжаар сумдын 2022 оны үйл ажиллагааг дүгнэхэд тус сум нь 94,2 хувьтай, “Ногоон хөгжил-Баялаг бүтээгчид”-ийг дэмжих урианы жилийн хэрэгжилт 93,5 хувьтай тус тус дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Эрдэнэ сумын Засаг дарга нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль Шилэн дансны тухай хууль зэргийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамрагдаагүй, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод хяналтын төлөвлөгөөг 2022 онд нийт 12 ажил үүрэг гүйцэтгэхээр төлөвлөн батлуулсан байна. Сумын Засаг даргын тамгын газрын даргаар томилогдсон ажлын хэсэг нь удирдамж батлуулан байгууллагуудын өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт, анхан шатны баримтын хөтлөлт, бараа материалын зарцуулалт, хөрөнгө оруулалтын ажлын явцын гүйцэтгэл, шилэн дансны хөтлөлт, Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж, зөвлөмж, хугацаатай үүрэг даалгавар өгч хэрэгжилтийг тооцон ажилласан байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын нэгтгэсэн тайланд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 3,997,558.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 5,150,088.9 мянган төгрөгөөр буюу 56,3 хувиар буурсан байна.

Хүснэгт 1 Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгөн хөрөнгө	460,385.50	1,618,074.93	1,157,689.43
Авлага	535,458.18	537,561.34	2,103.16
Бараа материал	315,757.52	263,160.93	-52,596.59
Үндсэн хөрөнгө	7,836,046.32	1,578,761.39	-6,257,284.92
Нийт хөрөнгө	9,147,647.51	3,997,558.59	-5,150,088.92
Өр төлбөр	36,291.30	12,687.34	-23,603.96
Засгийн газрын хуьт оролцоо /Эздийн өмч/	9,111,356.21	3,984,871.25	-5,126,484.96
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө / өмчийн дүн	9,147,647.51	3,997,558.59	-5,150,088.92

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 1,618,074.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,157,689.4 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь орон нутгийн ерөнхий орлогын дансны эцсийн үлдэгдэл 1,464,542.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,113,115.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Авлагын эцсийн үлдэгдэл 537,561.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,103.1 мянган төгрөгөөр өссөн нь орон нутгийн хөгжлийн сангийн авлага 91,885.6 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалсан байна.

Бараа материалын эцсийн үлдэгдэл 263,160.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 52,596.5 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих улсын төсвийн байгууллагууд харьяа байгууллагууддаа санхүүгийн тайлангаа нэгтгэдэг болсноор Эрүүл мэндийн төвийн 59,972.0 мянган төгрөг, ЕБС-ийн 52,635.4 мянган төгрөг, Цэцэрлэгийн 23,559.8 мянган төгрөг, Соёлын төвийн 10,644.1 мянган төгрөгийн, нийт 146,811.5 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлсэн нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 1,578,761.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 6,257,284.9 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих улсын төсвийн ЕБС, Цэцэрлэг, Эмнэлэг, Соёлын төвийн байгууллагуудын 8,692,710.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлснээс шалтгаалсан байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 3,984,871.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 5,126,484.9 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих улсын төсвийн ЕБС, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн, Соёлын төвийн байгууллагуудын авлага,

засгийн газрын сан, дахин үнэлгээний нэмэгдлийг өмнөх үеийн үр дүн дансанд хааж, тайлант оны үр дүн 1,092,344.1 мянган төгрөг болсноос шалтгаалсан байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 1,618,074.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,157,689.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2 Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банкинд байгаа бэлэн мөнгө	460,385.50	1,618,074.93	1,157,689.43
Төгрөг	460,385.50	1,618,074.93	1,157,689.43
Төрийн сангийн харилцах	457,899.03	1,616,884.74	1,158,985.71
Арилжааны банк дахь харилцах	2,449.47	1,190.19	-1,259.28
Нэмэлт санхүүжилтийн харилцах	37.00	0.00	-37.00
Дүн	460,385.50	1,618,074.93	1,157,689.43

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн Төрийн сангийн харилцах дансны эцсийн үлдэгдэл 1,618,074.9 мянган төгрөгийн 90,5 хувь буюу 1,464,542.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн орлогын, 7,3 хувь буюу 119,045.4 мянган төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн, 2,0 хувь буюу 33,296.3 мянган төгрөгийг хоршоо хөгжүүлэх сангийн үлдэгдэл тус тус байршиж байна.

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл өмнөх оноос 1,157,689.4 мянган төгрөгөөр өссөн нь орон нутгийн ерөнхий орлогын дансны эцсийн үлдэгдэл 1,464,542.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,113,115.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 537,561.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,103.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3 Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	38,217.41	-	-38,217.41
Байгууллагаас авах авлага	182,149.26	216,373.92	34,224.66
Хувь хүмүүсээс авах авлага	315,091.51	321,187.42	6,095.91
Дүн	535,458.18	537,561.34	2,103.16

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын жилийн эцсийн үлдэгдэл 537,561.3 мянган төгрөгийн 62,0 хувийг хувь буюу 336,295.3 мянган төгрөгийг хүмүүсээс авах авлага эзэлж байна. Энэ нь хоршоо хөгжүүлэх сангийн авлага байна.

3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 88,588.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 127,615.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Бараа материалын эцсийн үлдэгдэл 263,160.9 мянган төгрөгийн 55,495.8 мянган төгрөг буюу 21,0 хувийг эмийн эргэлтийн сан, 200,203.0 мянган төгрөг буюу 76,0 хувийг ЗДТГ, 7,462.0 мянган төгрөг буюу 2,8 хувийг ИТХ-ын бараа материал эзэлж байна.

Бараа материалын оны эцсийн үлдэгдэл 52,596.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих ЕБС-ийн 52,635.4 мянган төгрөг, Цэцэрлэгийн 23,559.8 мянган төгрөг, Эрүүл мэндийн төвийн 59,972.0 мянган төгрөг, Соёлын төвийн 10,644.1 мянган төгрөг, нийт 146,811.5 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдлийг улсын төсвийн байгууллагад шилжүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 4 Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	112,024.13	92,544.35	-19,479.79
Тусгай зориулалттай материал	41,037.83	25,976.04	-15,061.79
Эм боох материал	59,913.83	55,495.84	-4,417.99
Бэлэн бүтээгдэхүүн	11,072.47	11,072.47	0.00
Хангамжийн материал	166,426.72	133,559.92	-32,866.80
Бичиг хэргийн материал	733.20	248.00	-485.20
Аж ахуйн материал	51,303.36	15,614.76	-35,688.60
Сэлбэг хэрэгсэл	3,514.80	5,281.30	1,766.50
Түлш, шатах тослох материал	773.06	-	-773.06
Барилгын засварын материал	240.00	-	-240.00
Хүнсний материал	8,777.79	-	-8,777.79
Бусад хангамжийн материал	101,084.51	112,415.86	11,331.34
Мал амьтад	37,306.67	37,056.67	-250.00
Дүн	315,757.52	263,160.93	-52,596.59

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Аудитын илрүүлэлт

ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар:

- Тайлант хугацаанд 12,244.4 мянган төгрөгийн шатахууныг тооцоог бодоогүй зөрчилд зөвлөмж өгсөн.

3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 1,578,761.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 6,257,284.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгийн жилийн эцсийн 1,886,865.7 мянган төгрөгийн үлдэгдлийн 99,2 хувь буюу 1,872,487.1 мянган төгрөгийг сумын ЗДТГ, үлдэх хувийг эмийн эргэлтийн сан, ИТХ, сум хөгжүүлэх сангийн хөрөнгө эзэлж байна.

Хүснэгт 5 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	10,760,595.15	2,572,649.46	-8,187,945.69
Барилга, байгууламж, орон сууц	8,645,288.25	1,336,761.30	-7,308,526.96
Авто тээврийн хэрэгсэл	489,186.94	360,099.51	-129,087.43
Машин тоног төхөөрөмж	940,708.51	411,311.96	-529,396.55
Тавилга, аж ахуйн эд хогшил	286,052.69	51,766.30	-234,286.39
Зам, гүүрийн байгууламж	64,200.00	64,200.00	0.00
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	10,610.80	10,610.80	0.00
Бусад үндсэн хөрөнгө	289,132.34	337,899.59	48,767.25
Номын фонд	35,415.61	-	-35,415.61
Биет бус хөрөнгө	114,487.50	16,406.50	-98,081.00
Программ хангамж	5,935.00	4,672.50	-1,262.50
Бусад биет бус хөрөнгө	108,552.50	11,734.00	-96,818.50
Дүн	10,875,082.65	2,589,055.96	-8,286,026.69

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 2,801,581.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 313,394.8 мянган төгрөгөөр нэмэгдэж, гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих улсын төсвийн байгууллагууд ЕБС-ийн 1,892,900.6 мянган төгрөгийн, Цэцэрлэгийн 248,998.1 мянган төгрөгийн, Эрүүл мэндийн төвийн 434,456.6 мянган төгрөгийн, Соёлын төвийн 223,663.2 мянган төгрөгийн, нийт 2,800,018.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлсэнтэй холбоотой байна.

3.4.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 12,687.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 23,603.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 6 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/ мянган төгрөгөөр /			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Байгууллагад төлөх өглөг	36,278.45	12,478.71	-23,799.74
Хувь хүмүүст төлөх өглөг	12.85	118.20	105.35
Татварын өглөг /ТӨҮГ/	0.00	90.43	90.43
Дүн	36,291.30	12,687.34	-23,603.96

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 23,603.9 мянган төгрөгөөр буурсан нь ЭМТ-ийн 36,053.9 мянган төгрөгийн өглөгийг улсын төсвийн тайланд шилжсэнтэй холбоотой байна.

Өр төлбөрийн жилийн эцсийн 12,687.3 мянган төгрөгийн үлдэгдлийн 92,1 хувь буюу 11,693.7 мянган төгрөг нь эмийн эргэлтийн сангийн өглөг байна.

3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 3,984,771.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 5,126,584.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7 Засгийн газрын хувь оролцоо

/ мянган төгрөгөөр /			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал / Засгийн газрын сан / орон нутгийн сан	2,276,153.70	533,911.87	-1,742,241.83
Хуримтлагдсан үр дүн	6,835,202.52	3,450,859.39	-3,384,343.13
Өмнөх үеийн үр дүн	6,169,255.61	2,213,747.78	-3,955,507.83
Тайлант үеийн үр дүн	(275,214.46)	1,092,344.19	1,367,558.65
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	941,161.37	144,767.42	-796,393.95
Дүн	9,111,356.21	3,984,771.25	-5,126,584.96

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл өмнөх оноос 5,126,584.9 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих улсын төсвийн ЕБС, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн, Соёлын төвийн байгууллагуудын авлага, засгийн газрын сан, дахин үнэлгээний нэмэгдлийг өмнөх үеийн үр дүн дансанд хааж, тайлант оны үр дүн 1,092,344.1 мянган төгрөг болсноос шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төв аймгийн Эрдэнэ сумын орон нутгийн төсвийн байгууллагуудын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 948,784.4 мянган төгрөг, 2022 оны төсвийн жилийн урсгал үйл ажиллагааны зардлыг 1,827,814.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 71,081.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 1,019,866.1 мянган төгрөгөөр, урсгал үйл ажиллагааны зардлыг 271,221.1 мянган төгрөгөөр бууруулан 1,556,593.8 мянган төгрөгөөр, хоршоо хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг 129,208.0 мянган төгрөгөөр, ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжих төсөл арга хэмжээг 594,447.3 мянган төгрөгөөр, нийт 2,679,589.5 мянган төгрөгийг сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн “2022 оны төсөв батлах тухай” 26 дугаар тогтоолоор баталсан байна.

Энэ нь 2022 оны төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулсан боловч жил бүр орон нутгийн орлогын төлөвлөгөөг нэмж баталж, төсвийн урсгал зардал ИТХ-ын Төлөөлөгчдийн үйл ажиллагааны зардлыг хассантай холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны төсвийг тодотголоор орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 25,342.7 мянган төгрөгөөр нэмж 1,045,208.8 мянган төгрөгөөр, нийт урсгал үйл ажиллагааны зардлыг 25,342.7 мянган төгрөгөөр нэмж 1,101,420.7 мянган төгрөгөөр, хоршоо хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг 129,208.0 мянган төгрөгөөр, ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжих төсөл арга хэмжээг 594,447.3 мянган төгрөгөөр, нийт 2,546,349.1 мянган төгрөгийг сумын ИТХ-ын 2022 оны 7 дугаар сарын 06 -ны өдрийн “Сумын 2022 оны төсөвт тодотгол хийх тухай” 28 дугаар тогтоолоор тодотгон баталсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн 21 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвийн орлогоос 1,045,208.8 мянган төгрөг, орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгээс 613,223.0 мянган төгрөг, ОНХС-д олгох орлогын шилжүүлэг 349,262.3 мянган төгрөг, ОНХС-ийн шилжих үлдэгдлээс 116,997.0 мянган төгрөг, төсвийн урьд оны шилжих үлдэгдлээс 292,450.0 мянган төгрөг, хоршоо хөгжүүлэх сангийн эх үүсвэрээс 129,208.0 мянган төгрөгийг бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,889,298.6 мянган төгрөгийн санхүүжилт олгож, орон нутгийн төсөвт 109,097.8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,149,818.0 мянган төгрөг буюу 84,4 хувьтай байгаа нь орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл 58,7 хувьтай, хоршоо хөгжүүлэх сангийн гүйцэтгэл 62,3 хувьтай байгаатай холбоотой байна.

Хүснэгт 8 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	ИТХ-ын үйл ажиллагаа	142,376.5	140,797.6	1,578.9	98,8%
2	ЗДТГ-ын үйл ажиллагаа	1,057,699.5	967,826.4	89,873.1	91,5%
3	ЕБС-үйлчилгээ	439,160.3	448,264.6		99,8%
4	Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ	95,988.4	91,489.2	4,499.2	95,3%
5	Соёл урлагийн үйлчилгээ	62,916.4	60,338.0	2,578.4	95,9%
6	ЭМТ-ийн үйлчилгээ	24,552.7	21,484.8	3,067.9	87,5%
7	Хөрөнгө оруулалт хөтөлбөр төсөл арга хэмжээ	594,447.3	349,021.5	245,425.8	58,7%
8	Хоршоо хөгжүүлэх сан	129,208.0	80,596.0	80,596.0	62,3%
	Нийт	2,546,349.1	2,149,818.0	39,6531.1	84,4%

Батлагдсан төсөв. гүйцэтгэл. түүний хэтрэлт. хэмнэлтийг орлого. зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв. түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн харилцах дансаар сумын Засаг даргын тамгын газар нь 368,693.6 мянган төгрөг, ЭМТ 37.0 мянган төгрөг, Соёлын төв 3,059.1 мянган төгрөг нийт 371,789.7 мянган төгрөгийг зарцуулсан байна

Нэмэлт төсвийн тайланг орлого. зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат. хүрэх үр дүн

Тус төсөл хөтөлбөр хэрэгжих хугацаанд нийт 8 хөтөлбөрийн 21 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 9 Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн. биелэлт

/ мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70105- Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	2022.01.01 2022.12.31	Сумын ИТХТ, тэргүүлэгчдийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажил үйлчилгээгээр хангах, мэргэшсэн тогтвортой өндөр чадавх бүхий аппарат бүрдүүлж, хуралдааныг зохион байгуулж, мэдээллээр тасралтгүй хангахад оршино. Жилд 4-өөс доошгүй удаа хурал хийнэ.	Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч, тэргүүлэгчдийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажил үйлчилгээгээр хангах, мэргэшсэн тогтвортой өндөр чадавх бүхий аппарат бүрдүүлж, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын, тэргүүлэгчдийн хуралдааныг зохион байгуулж жилд 12 удаа хуралдсан байна. Хэрэгжилт 99.4 %	142,376.5	140,797.6
2	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2022.01.01 2022.12.31	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 4 зорилт, хэрэгжүүлэх 78 арга хэмжээ хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт 98,6%	105,7699.5	967,826.4
3	70106-Хоршоо хөгжүүлэх сан	2022.01.01 2022.12.31	2022 оны 1 сараас Сум хөгжүүлэх санг шинээр Хоршоо хөгжүүлэх сан болгон журмыг дагаж мөрдөх ХХС-аас иргэн, хоршоонд олгох зээлийг журмын дагуу шаардлага хангасан төсөл шалгаруулан зээл олгох	2022 оны 01 сараас Хоршоо хөгжүүлэх сан болж журмын дагуу шинэчлэгдсэн. Хэрэгжилт 100% Хоршоо хөгжүүлэх сангаас зээл олгох төсөл хөтөлбөр зээлийн сонгон шалгаруулалт зарлагдаж тэнцсэн материал ирүүлээгүй байна.	129,208.0	80,596.0
4	71802-Ерөнхий боловсролын сургууль	2022.01.01 2022.12.31	Ерөнхий боловсрол сургууль нь 9 зорилт 31 арга хэмжээ хэрэгжүүлэх	2022 онд “Багшийн гүйцэтгэлийн үнэлгээ” сургуулийн дундаж 67%, Хөтөлбөрийн хэрэгжилт 91.4%	439,160.3	438,264.5
5	71801-Сургуулийн өмнөх боловсрол	2022.01.01 2022.12.31	Сургуулийн өмнөх боловсрол нь 14 зорилт 51 арга хэмжээ хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт 71.5 %	95,988.4	91,489.2
6	71702-Соёлын үйлчилгээ	2022.01.01 2022.12.31	Соёлын төв нь 6 зорилт 32 арга хэмжээ хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт 97.0%	62,916.4	60,338.0

7	71602-Эрүүл мэндийн төв	2022.01.01 2022.12.31	Нийт 8 төрлийн үзлэгт 2385 хүн, Эрүүл мэндийн даатгалын 4 багцын тусламж үйлчилгээнд 364 иргэдийг хамруулна.	Нийт 8 төрлийн эрт илрүүлэг үзлэгт 2897 хүн, чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэгт 660/100%, артерийн даралтны эрт илрүүлэг 1119/100%, хөхний хавдар илрүүлэх үзлэгт 362/91.1%, умайн хүзүүний эрт илрүүлэг 44/57.8% БЗДХ илрүүлэх 463/92.3%%, элэгний В С илрүүлэгт 249/88.6% иргэн хамрагдаж нийт 88.3%. байна ЭМД-ын 4 багцын тусламж үйлчилгээний Өдрийн эмчилгээний багц- 46 иргэн Сэргээн засах эмчилгээний багц 73 иргэн гэрийн эргэлтийн багцад- 102 иргэн, Оношилгоо шинжилгээний багц 312 иргэн нийт 533 иргэн тус тус хамрагдсан	24,552.7	21,484.8
8	70106-Орон нутгийн хөгжлийн сан	2022.01.01 2022.12.31	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр шинээр хэрэгжих 11 төслийг 204889.6 мянган төгрөгөөр хийж гүйцэтгэнэ.	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 11, мөнгийг нь дутуу шилжүүлсэн 3 ажил байна. Хэрэгжилт 95.4%	594,447.3	349,021.5
Нийт дүн					2,546,349.1	2,149,818.0

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын орлого бүрдүүлэлт, шилэн дансны мэдээллийг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Хүрэлбаатар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт сумын Засаг даргын 2023 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн 01/41 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн, суурь үзүүлэлтийг нийт орлого 4.317.994.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 64.769.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 48.577.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг дарга нь Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар мэдээлэл ирүүлээгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын шилэн дансны цахим хуудсанд тайлант онд байршуулбал зохих мэдээлбэл зохих 171 мэдээллээс хугацаа хоцроосон 32 мэдээлэл, мэдээлээгүй мэдээлэл байхгүй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн. өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн, сумын Засаг даргын 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 01/142 дугаартай албан бичгээр хэрэгжилтийг ирүүлсэн байна.

Хүснэгт 10 Төлбөрийн акт. албан шаардлага. зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	2.601.0	1	2.601.0	100%
Албан шаардлага	1	33.134.4	1	33.134.4	100%
Зөвлөмж	4	14.929.2	4	14.929.2	100%
Нийт дүн	6	50.664.6	6	50.664.6	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар залруулга хийгдээгүй ба 108.120.9 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд 2 зөвлөмж өгсөн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Орлогын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Орон нутгийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээр биелсэн боловч 4 нэр төрлөөр 108,120.9 мянган төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь. төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт. төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар. улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ", 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Орон нутгийн орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр жигд ханган биелүүлэх.

Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Шилэн дансанд мэдээлбэл зохих 171 мэдээллээс хугацаа хоцроосон 32 мэдээлэл байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв.

бодитой. иж бүрэн байх", 4.1.2-т "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх" гэж заасантай бүрэн нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансанд байршуулах мэдээллийг цаг хугацаанд нь иж бүрэн мэдээлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЭЭСан	1	1.910.2			1	1.910.2	1	1.910.2		
Дүн	1	1.910.2			1	1.910.2	1	1.910.2		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
Засаг дарга	1	108.120.9					1	108.120.9		
ЗДТГ	2	91.680.3			1	79.435.9	1	12.244.4		
ИТХ	1	3.349.6					1	3.349.6		
ХХСан	2	40.000.0			1	20.000.0	1	20.000.0		
Дүн	6	243.150.8			2	99.435.9	4	143.714.9		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Засаг дарга	1	0.0							0.0
ЭЭС	1	7.683.0							7.683.0
ОНХС	1	0.0							0.0
Эрдэнэ тохижилт үйлчилгээ	1	0.0							0.0
Дүн	4	7.683.0							7.683.0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Дүн									
Нийт дүн	4	7.683.0							7.683.0